



The Asia Foundation

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ
АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГАА

2018

Canada 


The Asia Foundation


Sant-Maral Foundation

Энэхүү судалгааг Канадын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр Азийн сан, Сант Марал Сантай хамтран явуулсан бөгөөд судалгааны үр дүн Канадын Засгийн газар болон Канадын Гадаад хэргийн яамны байр суурийг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ
АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГАА

2018

АГУУЛГА

Товчлол.....	3
Хүснэгт дүрсийн жагсаалт	4
ОРШИЛ.....	7
СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН.....	8
СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ	10
I. ТҮҮВРИЙН ТОДОРХОЙЛОЛТ.....	11
II. БИЗНЕСИЙН ОРЧИН	19
III. БИЗНЕСИЙН ОРЧНЫ СААД БЭРХШЭЭЛ	27
IV. АЛДАГДАЛ БУЮУ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛАЛТ.....	31
V. ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АВЛИГА	35
VI. ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ АВЛИГА	45
VII. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	57

ТОВЧЛОЛ

МБ	Мэдэхгүй байна
ТАА	Төрийн албан дахь авлига
ХА	Хариулт алга
ЕС	Ерөнхий Сайд
СМС	Сант Марал Сан
АТОНОМТС	Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа
БЭОАНБС	Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгаа
АС	Азийн Сан
УБ	Улаанбаатар
₮	Төгрөг
ДБ	Дэлхийн Банк
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

ХҮСНЭГТ ДҮРСИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1	Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн хуваарилалт /газар зүйн байршлаар/	13
Зураг 1.2	Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл.....	13
Зураг 1.3	Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл.....	14
Зураг 1.4	Хөрөнгийн хэмжээ.....	14
Зураг 1.5	Үүсэн байгуулагдсан он.....	15
Зураг 1.6	Удирдах түвшин дэх хүйсийн харьцаа.....	15
Зураг 1.7	Хүйсийн харьцаа, компаний хэмжээгээр (нэгтгэсэн түүвэр).....	16
Зураг 1.8	Хүйсийн харьцаа, компаний үйл ажиллагааны чиглэлээр (нэгтгэсэн түүвэр, тохиолдлоор).....	16
Зураг 1.9	Удирдах албан тушаал, хүйсээр (нэгтгэсэн түүвэр).....	17
Зураг 2.1	Монголын бизнес эрхлэлтийн ерөнхий орчны сэтгэл ханамжийн байдал	20
Зураг 2.2	Бизнесийн орчны үнэлгээний дундаж (маш сэтгэл хангалуун: +2, харьцангуй сэтгэл хангалуун: +1, бага зэрэг сэтгэл хангалуун бус: -1, огт сэтгэл хангалуун бус: -2).....	21
Зураг 2.3	Бизнес эрхлэлтийн ерөнхий орчны сэтгэл ханамжийн байдал, хүйсээр (2017-2018).....	21
Зураг 2.4	Бизнесийн орчин дахь сэтгэл ханамжийн байдал, компаний хэмжээгээр (2018)	22
Зураг 2.5	Дундаж үнэлгээ, компаний хэмжээгээр (2012-2018).....	22
Зураг 2.6	Дундаж үнэлгээ, компаний үйл ажиллагааны чиглэлээр (2012-2018).....	23
Зураг 2.7	Сүүлийн 6 сарын хугацаанд компаний үйл ажиллагаан дахь хөрөнгө оруулалтын нөхцөл байдал	23
Зураг 2.8	Ирэх 6 сарын хугацаанд танай компаний үйл ажиллагаан дахь хөрөнгө оруулалтын нөхцөл байдал	24
Зураг 2.9	Сүүлийн 6 сарын хугацаанд компаний үйл ажиллагаан дахь хөрөнгө оруулалтын нөхцөл байдал (хүйсээр, 2018)	24
Зураг 2.10	Ирэх 6 сарын хугацаанд танай компаний үйл ажиллагаан дахь хөрөнгө оруулалтын нөхцөл байдал (хүйсээр, 2018)	25
Зураг 2.11	Засгийн газраас явуулсан эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн үр дүн.....	25
Зураг 2.12	Эдийн засгийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх Засгийн газрын чадавхи	26
Зураг 3.1	Бизнесийн орчны үндсэн саад бэрхшээлүүд (олон сонголттой).....	28
Зураг 3.2	Бизнес тулгарч буй хамгийн гол 3 саад бэрхшээлийн 2012-2018 онуудын чиг хандлага.....	29

Зураг 3.3	2012-2017 оны хооронд саад бэрхшээл учруулж буй тэргүүлэх 4 төрийн байгууллагын чиг хандлага (олон сонголт)	29
Зураг 3.4	2018 оны байдлаар саад бэрхшээл учруулж буй төрийн байгууллагууд (нэг сонголттой)	30
Зураг 3.5	Саад бэрхшээл учруулж буй төрийн байгууллагууд, хүйсээр (нэгтгэсэн)	30
Зураг 4.1	Үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд компаний удирдлагын зарцуулж буй цаг хугацаа	32
Зураг 4.2	Үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд байгууллагаас зарцуулж буй нөөц	33
Зураг 4.3	Үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд компаний удирдлагын зарцуулж буй цаг хугацаа (2018, хүйсээр).....	33
Зураг 4.4	Үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд байгууллагаас зарцуулж буй нөөц (2018, хүйсээр)	34
Зураг 5.1	Таны бодлоор төрийн түвшинд авлига хэр их байгаа вэ?	36
Зураг 5.2	Төрийн албан дахь авлига (Үнэлгээ – 1: “маш их”, 2: “тодорхой хэмжээнд байгаа”, 3: “бага зэрэг”, 4: “байхгүй”)	37
Зураг 5.3	Танай салбар дахь төр болон хувийн компанийн харилцаанд авлигын чанартай зүйл байгааг та хамгийн сүүлд хэзээ ажигласан бэ? (зөвхөн бодит хариултууд).....	37
Зураг 5.4	Төрийн тендерт оролцох, гэрээ байгуулахад авлигатай тулгарч буй давтамж.....	38
Зураг 5.5	Төрийн албан дахь авлигын дундаж давтамж (1-ээс буюу “байнга” 4 хүртэл буюу “хэзээ ч гардаггүй”).....	38
Зураг 5.6	Таны бизнесийн үйл ажиллагааны өнцгөөс ажигласнаар төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас аль нь авлигад хамгийн ихээр өртсөн бэ? (олон сонголттой)	39
Зураг 5.7	Төрийн албан дахь авлигын шууд нөлөөлөл	41
Зураг 5.8	Төрийн албан дахь авлигын бизнесийн үйл ажиллагаанд үзүүлж буй нөлөө	41
Зураг 5.9	Засгийн газрын тендерт оролцсон байдал	42
Зураг 5.10	Их авлига буюу дээд түвшний авлига бизнест үзүүлж буй нөлөө	42
Зураг 5.11	Төрийн албан дахь авлигын тархалтын суваг	43
Зураг 6.1	Хувийн хэвшил дэх авлигын үнэлгээ	46
Зураг 6.2	Хувийн хэвшил дэх авлига (хүйсээр)	47
Зураг 6.3	Хувийн хэвшлийн салбарт гэрээ байгуулах болон тендерт оролцох үйл ажиллагаан дахь авлига.....	48

Зураг 6.4	Танай бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулахад авлига хэр их тохиолддог вэ?.....	49
Зураг 6.5	Танай салбарын бизнесийн үйл ажиллагаанд авлига хэр их тохиолддог вэ?	51
Зураг 6.6	Авлигад хамгийн ихээр өртөмтгий салбарууд (олон сонголттой).....	53
Зураг 6.7	Танай салбарт хэр олон компаниуд татвараа номоор нь /хууль ёсны дагуу/ төлдөг вэ? (зөвхөн бодит)	56
Зураг 7.1	Та одоогийн Засгийн газраас явуулж байгаа авлигын эсрэг үйл ажиллагааны талаар хэр сайн мэдэх вэ?	58
Зураг 7.2	Бизнесийн орчныг ил тод, авлигаас ангид болгоход хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын үр ашигтай байдал.....	59
Зураг 7.3	Засгийн газраас авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөө	60
Зураг 7.4	Таны бодлоор Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээнүүд Монголыг авлигагүй болгоход хэр үр дүнтэй байгаа вэ?	60
Зураг 7.5	Таны бодлоор Засгийн газар авлигад өртсөн төрийн албан тушаалтнуудыг хэрхэн хариуцлагад татаж чадаж байна вэ?.....	62
Зураг 7.6	АТГ-аас авлигатай тэмцэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны үнэлгээ.....	62
Зураг 7.7	АТГ-ын явж буй чиглэл	63
Зураг 7.8	Төрийн албан дахь авлигын хэмжээ буурснаар үзүүлэх үр нөлөө.....	63
Зураг 7.9	Төрийн албаны авлига багассанаар танай компаний ашиг орлого буурах эсэх	64
Зураг 7.10	Авлигатай тэмцэх чиглэлээр хийсэн алхмууд	64
Зураг 7.11	Авлигын тохиолдлын талаар мэдүүлсэн байдал.....	65
Зураг 7.12	Хэрэв тийм бол, үр дүнд хүрсэн эсэх	65
Зураг 7.13	Авлигатай тэмцэх дотоод журамтай эсэх.....	66
Зураг 7.14	Бизнесийн орчин дахь авлигын эсрэг үйл ажиллагаа	66
Хүснэгт 6.1	Авлигын гэмт хэргээс учирсан хохирол (тэрбум ₮).....	46
Хүснэгт 7.1	Авлигатай тэмцэх газраас шалгаад, прокурорт шилжүүлсэн хэргийн тоо	61

ОРШИЛ

Азийн Сан “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” судалгааг Сант Марал Сантай хамтран нийслэл Улаанбаатар хотод байрладаг аж ахуйн нэгжүүдийн дунд 2018 оны 10-р сард ес дэх удаагаа явууллаа.

Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгаа нь Канадын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр Азийн Сангаас хэрэгжүүлж буй “Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь” (STEPS) төслийн үйл ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ судалгаа нь бизнес эрхлэгчдийн ойлголт, төсөөлөлд тулгуурлан авлига бизнесийн орчинд хэрхэн нөлөөлж буйг харуулахыг зорьдог.

Судалгааны урт хугацааны туршид үргэлжлэх давтамж нь авлигын талаарх ойлголт, хандлагад гарч буй урт хугацааны өөрчлөлт, чиг хандлагыг харьцуулах, үнэлэх боломжийг олгодог юм. Судалгааны зорилго нь бизнес эрхлэгчид, бодлого тодорхойлогчид, ялангуяа төрийн үйлчилгээний байгууллагуудын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, цаашлаад тэдгээрийн сайн засаглалын туршлагыг бэхжүүлэх, хандлагыг өөрчлөх мөн авлигаас урьдчилан сэргийлэхэд шаардагдах арга замыг тодорхойлоход оршино.

Түүнчлэн Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгаа нь Азийн Сан, Сант Марал Сангийн Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгааны нэг хэсэг юм. Энэ хоёр судалгаа нь хамтдаа Монгол Улсын авлигын түвшинг өргөн дүр зургаар нь харуулж өгдөг юм.

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

- Хэдийгээр эдийн засаг сэргэх тодорхой шинж тэмдэг харагдаж байгаа ч 2017 оныхтой харьцуулахад бизнесийн орчин дордсон гэж бизнес эрхлэгчид үзэж байна. 2018 онд сөрөг үнэлгээ 84.8 хувьтай байгаа нь өмнөх жилээс 3.9 хувиар өссөн үзүүлэлт юм. 2016-2017 оны хооронд үнэлгээнд гарсан эерэг өөрчлөлт нь 2018 онд эсрэгээрээ өөрчлөгдсөн байна.
- Аж ахуйн нэгжүүдэд тулгардаг асуудлууд болох татварын хэмжээ болон мэргэжлийн үр чадварын нөхцөл байдал 2017 оны түвшнээс мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн байна. “Татварын өндөр хувь хэмжээ” болон “тусгай зөвшөөрөл, лицензийн сунгалт” нь бизнест тулгарч буй томоохон саад бэрхшээл хэвээр байгаа бол ажиллах хүчний “мэргэжил үр чадварын дутмаг байдал” нь эдийн засагт сөргөөр нөлөөлөхүйц, томоохон асуудал болж буй сөрөг хүчин зүйл болоод байна.
- Бизнесийн ерөнхий орчны сөрөг үнэлгээ нэмэгдсэн хэдий ч 2017 онтой харьцуулахад бизнес эрхлэгчид сүүлийн 6 сарын хөрөнгө оруулалтын орчин болон ирэх 6 сарын хөрөнгө оруулалтын төлөв байдал, боломжуудыг илүү өөдрөгөөр харж байна. 2018 онд, судалгаанд оролцогчдын 24.2 хувь нь сүүлийн 6 сард хөрөнгө оруулалтын орчны нөхцөл байдал “сайжирсан” гэж дүгнэсэн бол, энэ тоо 2017 онд 17.3 хувь, 2016 онд 10 хувь байсан байна. 2018 онд судалгаанд оролцогчдын 41.2 хувь нь ирэх 6 сард нөхцөл байдал дээрдэнэ гэсэн хүлээлттэй байгаа бол энэ тоо 2017 онд 44.8 хувь, 2016 онд дөнгөж 26.4 хувьтай байсан байна.
- Хөрөнгө оруулалтын нөхцөл байдал сайжирна гэсэн олон нийтийн хүлээлт нь Засгийн газрын аливаа дэмжлэгт тулгуурлаагүй бөгөөд судалгаанд оролцогчдын дийлэнх олонх нь нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр Засгийн газраас дорвитой эдийн засгийн бодлого явуулна гэдэгт итгэхгүй байгаагаа илэрхийлсэн байна.
- Судалгаанд оролцогчид Татварын алба, Мэргэжлийн хяналт болон Гаалийн байгууллагыг бизнес эрхлэхэд хамгийн их саад бэрхшээл үчруулж буй төрийн байгууллагаар онцлон нэрлэсэн байна. Мөн дээрхи гурван байгууллага авлигад хамгийн ихээр өртсөн байгууллагаар нэрлэгдсэн байна.
- Байгууллагын удирдлагуудын үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацаа багасч байгааг мэдээлэх судалгаанд оролцогчдын чиг хандлага 2014 оноос хойш ажиглагдаж байгаа юм. Хэдий тийм ч үүнд хөрөнгө мөнгө зарцуулж байгаа хувь хэмжээ дордсон үзүүлэлттэй байна. 2018 онд судалгаанд оролцогчдын 9,4 хувь нь өөрийн нийт хөрөнгийн нөөцийн 25-аас илүү хувийг зарцуулсан бол 2017 онд энэ тоо 7 хувьтай байсан байна.
- 2016 оноос хойш төрийн албан дахь авлигын нөхцөл байдал бага зэрэг сайжирсан үзүүлэлттэй байгаа хэдий ч хувийн хэвшил дэх авлигын түвшинтэй харьцуулахад муу үзүүлэлт хэвээр байгаа юм. 2018 оны байдлаар төрийн албан дахь авлигын давтамж, хамрах хүрээ 2017 оныхтой

харьцуулахад буурсан үзүүлэлттэй байгаа нь 2012 оноос хойш бага зэрэг боловч тогтвортойгоор буурч буй чиг хандлагыг үргэлжлүүлж байна. “Төрийн үйлчилгээ” нь авлигад хамгийн ихээр өртөмтгий салбарт тооцогдсон хэвээр байна.

- 2015-2018 оны хооронд судалгаанд оролцогчдын бараг тэн хагас нь төрийн албаны авлига тэдгээрийн бизнест “маш ихээр” буюу “тодорхой хэмжээнд” нөлөөлсөн гэж мэдэгдсэн байна.
- Авлигын тархалтыг зогсоох чиглэлд Засгийн газраас гаргаж буй хүчин чармайлт болон хууль эрхзүйн тогтолцоонд итгэх бизнес эрхлэгчдийн итгэл сул байна. Энэхүү үл итгэсэн байдал цаг хугацаа өнгөрөх тусам өсөн нэмэгдсээр байна.
- АТГ-ын үйл ажиллагаанд өгөх үнэлгээ ихэнхи хугацаанд сөрөг байсан бөгөөд 2018 онд судалгаанд оролцогчдын 41.5 хувь нь тус байгууллагын үйл ажиллагааг зөв биш байна гэж үзсэн байна.
- Хууль, дүрэм журмын дагуу бизнес эрхлэх нь компаниудын хувьд авлигыг бууруулах хамгийн шилдэг аргаар тооцогдсон хэвээр байна. 2018 онд авлигатай тэмцэх бодлогын баримт бичиг боловсруулсан компаниудын хувь хэмжээ 2017 оныхтой харьцуулахад 20 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

1. Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Австралийн гадаад хэрэг, худалдааны яам болон Канадын гадаад хэргийн яамны санхүүжилтээр Азийн сан болон Сант марал сан хамтран хэрэгжүүлсэн болно. 2012 оноос хойш нийтдээ 2970 судалгааны ярилцлага хийгдсэн болно.
2. Сант Марал Сан 2018 оны судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2018 оны 9-р сарын 24-ны өдөр эхлүүлэн 10-р сарын 16-ны өдөр дуусгав.
3. Судалгаанд оролцогчид нь Улаанбаатар хотын бизнесүүд бөгөөд өмнөх судалгаануудын үеэр цуглуулсан мэдээлэлд үндэслэн нийслэл хотод байрладаг аж ахуйн нэгжүүдийн тогтмол шинэчлэгддэг жагсаалтыг үүсгэж ашиглав. 2018 оны судалгаанд оролцуулахаар нийт 1860 аж ахуйн нэгжээс 330 аж ахуйн нэгжийг сонгон авав. Томоохон аж ахуйн нэгжүүд цөөн тул зарим оны судалгаанд давхардан орсон байх боломжтой бөгөөд жижиг болон дунд хэмжээний аж ахуйн нэгжүүд судалгаанд санамсаргүй түүврийн байдлаар хамрагдсан болно. Судалгаанд зөвхөн 100 хувь Монголын эзэмшил бүхий аж ахуйн нэгжүүд хамрагдсан болно.
4. 330 судалгаанд оролцогчдын түүвэрлэлтийн явцад гарсан түүврийн алдаа дараах байдлаар тооцоолсон байна: 90/10 хувьд ± 3.2 хувь, 50/50 хувьд ± 5.4 хувь, 60/40 хувьд ± 5.3 хувь ба харьцуулж буй бүлгүүдийн статистикийн ач холбогдлын түвшин 95 хувь байна.
5. Мэдээлэл цуглуулахад судалгаанд оролцогчид бие даан хариултыг ирүүлэх эсвэл ганцаарчилсан уулзалт, ярилцлагын аргыг ашигласан болно.
6. Уулзалт, ярилцлагыг зөвхөн компанийн гүйцэтгэх захирал, эсхүл удирдах түвшний албан тушаалтантай хийсэн болно.

ТҮҮВРИЙН ТОДОРХОЙЛОЛТ



I. ТҮҮВРИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2012-2018 оны хооронд хийгдсэн судалгааны оролцогчдын УБ-ын 6 дүүрэгт хуваарилсан түүвэрлэлтийн бүтэц хэвээр хадгалагдсан болно (Зураг 1.1). Гэсэн хэдий ч 2018 онд Монголын эдийн засагт бүтцийн шинж чанартай өөрчлөлтүүд бий болсныг гэрчлэх нотолгоо олон байгаа нь судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэлээс харагдаж байна (Зураг 1.2). Сүүлийн 7 жилд үйлчилгээний салбар дахь аж ахуйн нэгжүүдийн тоо ихээр нэмэгдсэн нь ажиглагдаж байна. Нөгөө талдаа, худалдааны салбарт бууралт ажиглагдаж байгаа бол (Зураг 1.3). үйлдвэрлэлийн салбар хэвэндээ үлдсэн байна. Эдгээр өөрчлөлтүүд нь хэд хэдэн хүчин зүйлээс хамааралтай байж болох ч, 2016 оноос хойш ажиглагдаж эхэлсэн эдийн засгийн сэргэлт болон банкуудын зээлийн бүтцэд хийгдсэн өөрчлөлтүүдээс үүдэн бий болсон үр дүн гэдэг нь үнэнд илүү ойр байгаа юм.


2018 оны түүвэрлэлтэд аж ахуйн нэгжийн хэмжээний харьцаа 2017 оныхтой ижил түвшинд байна (Зураг 1.4). Аж ахуйн нэгжийн хэмжээний шалгуурыг 2012 онд Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй төслийн хүрээнд СМС-аас боловсруулан гаргасан хэдий ч цаашид улам нарийвчлан сайжруулах шаардлага бий.

Аж ахуйн нэгжүүдийг үүсэн байгуулагдсан цаг хугацааны хувьд 3 ангилав. 2018 оны байдлаар 2000 оноос өмнө байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо тогтвортой хэвээр байгаа бол 2007 оноос хойш байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийн хувь хэмжээ 2017 оныхтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна (Зураг 1.5). Саяхны эдийн засгийн үналтаас шалтгаалан Монголчууд шинээр компани байгуулах тал дээр болгоомжтой хандсан хэвээр байна гэж хэлж болохоор байна.


Өөр нэг өөрчлөлт нь топ компаниудын удирдлагын түвшин дэх хүйсийн тэнцвэрт байдал юм. Хэдийгээр 2017 онд удирдлагын түвшин дэх хүйсийн харьцааны түүвэр улсын хэмжээний хүйсийн харьцааны дундажтай ойролцоо буюу 54.3 хувь нь эмэгтэй, 45.7 хувь нь эрэгтэй байсан ч 2018 онд энэ байдал 65.8 хувь нь эмэгтэй, үлдсэн 34.8 хувь нь эрэгтэй болж өөрчлөгдсөн байна (Зураг 1.6). Дүн шинжилгээ хийх боломжтой зөвхөн хоёр санал асуулга байгаа тул дээрхи өөрчлөлтийн талаар ямарваа нэгэн дүгнэлт хийхэд хүндрэлтэй юм. Улсын дундажтай харьцуулахад удирдлагын түвшин дэх эмэгтэйчүүдийн хувь өндөр байгаа нь хэмжээ нь жижиг болон том хэмжээний аж ахуйн нэгжүүд дээр мөн ажиглагдаж байна (Зураг 1.7). Дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл бүхий судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй байна.



Жижиг болон томоохон бизнесүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь улсын дундажтай харьцуулахад өндөр байгаа нь ажиглагдаж байна. Дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийг төлөөлж судалгаанд оролцсон хүмүүсийн хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй байна. Компани дахь албан тушаалын хуваарилалтаар нь авч үзвэл, гүйцэтгэх захирлын албан тушаалд эрэгтэйчүүд давамгайлсан буюу эмэгтэйчүүд 41.1 хувь, эрэгтэйчүүд 58.9 хувийг эзэлж байна (Зураг 1.9). Бусад удирдах түвшний санхүү эрхэлсэн захирал, оффис хариуцсан менежер зэрэг албан тушаалд эмэгтэйчүүд давамгайлж байгаа буюу эмэгтэйчүүд 72.8 хувийг, эрэгтэйчүүд 27.8 хувийг эзэлж байна.

Зураг 1.1. Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн хуваарилалт /газар зүйн байршлаар/




Зураг 1.2. Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл






Зураг 1.3. Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл**Зураг 1.4.** Хөрөнгийн хэмжээ


Зураг 1.5. Үүсэн байгуулагдсан он



Зураг 1.6. Удирдах түвшин дэх хүйсийн харьцаа



Зурар 1.7. Хүйсийн харьцаа, компаний хэмжээгээр (нэгтгэсэн түүвэр)**Зурар 1.8.** Хүйсийн бүтэц, компаний үйл ажиллагааны чиглэлээр (нэгтгэсэн түүвэр, тохиолдлоор)

Зураг 1.9. Удирдах албан тушаал, хүйсээр (нэгтгэсэн түүвэр)

БИЗНЕСИЙН ОРЧИН




II. БИЗНЕСИЙН ОРЧИН


Дэлхийн Банк (ДБ)-наас эрхлэн гаргадаг “Монголын эдийн засгийн тойм”-ын 2018 оны 7-р сарын дугаарт 2017 он бол Монгол Улсын хувьд эдийн засгийн хүчтэй сэргэлт бүхий таатай жил байсан бөгөөд 2018 онд Монголын эдийн засгийн үзүүлэлтүүд улам сайжрах төлөвтэй байгаа талаар мэдээлсэн. Бизнесийн орчны үнэлгээтэй холбоотой бидний олж авсан тоо баримтаас үзэхэд 2017 онд нөхцөл байдал сайжирсан нь харагдаж байгаа бөгөөд энэ нь эдийн засаг сэргэснийг гэрчилж байгаа юм. Гэсэн хэдий ч 2018 онд Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааны оролцогчид бизнесийн орчинд сэтгэл хангалуун бус байна.

2016-2017 онд бизнесийн орчны үнэлгээнд гарсан эерэг өөрчлөлт 2018 оны 9-р сарын байдлаар өөрчлөгдсөн байна (Зураг 2.1). Бизнесийн орчны сөрөг үнэлгээ 3.9 хувиар нэмэгдсэн бол эерэг үнэлгээ нь 4.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Ерөнхийдөө 2018 оны түвшин 2016 оныхтой ойролцоо хэмжээнд байгаа бөгөөд энэхүү чиг хандлага нь он тус бүрийн судалгаанд оролцогчдын өгсөн хариултын дунджаар мөн баталгаажиж байгаа юм (Зураг 2.2). 2017 оны -0.83-тай харьцуулахад 2016 оны дундаж -1.0 байна. 2018 онд дундаж нь -0.95 болсон байна. 2018 оны энэхүү сөрөг чиг хандлагыг бий болгоход “огт сэтгэл хангалуун бус” байгаа, судалгаанд оролцогч олон тооны эмэгтэй менежерүүд хүчтэйгээр нөлөөлсөн байна. Тэдний тоо 2017 онд 19.9 хувьтай байсан бол 2018 онд 25.8 хувь болж өссөн үзүүлэлттэй байна (Зураг 2.3).


Зураг 2.1. Монголын бизнес эрхлэлтийн ерөнхий орчны талаарх сэтгэл ханамжийн байдал



Зураг 2.2. Бизнесийн орчны үнэлгээний дундаж (маш сэтгэл хангалуун: +2, харьцангуй сэтгэл хангалуун: +1, бага зэрэг сэтгэл хангалуун бус: -1, огт сэтгэл хангалуун бус: -2)




Зураг 2.3. Бизнес эрхлэлтийн ерөнхий орчны сэтгэл ханамжийн байдал, хүйсээр (2017-2018)





2017 онд, судалгаанд оролцогч жижиг аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл нь дунд болон томоохон аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад бизнесийн орчинд нилээд сэтгэл хангалуун байсан. Энэхүү нөхцөл байдал нь 2018 онд өөрчлөгдсөн бөгөөд энэ удаагийн судалгаагаар бизнесийн хэмжээ болон өсөн нэмэгдэж буй сэтгэл хангалуун бус байдлын хооронд харилцан хамаарал байгаа нь ажиглагдлаа (Зураг 2.4-2.5). Аж ахуйн нэгж жижиг байх тусам эзэд нь улам бүр сэтгэл хангалуун бус байна. Аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааны чиглэлээр нь харвал судалгаанд оролцогчдын барилгын салбарын төлөөлөл хамгийн сэтгэл хангалуун бус байна. Удаах байранд үйлдвэрлэл болон уул уурхайн салбарынхан орж байна (Зураг 2.6).

Зураг 2.4. Бизнесийн орчин дахь сэтгэл ханамжийн байдал, компаний хэмжээгээр (2018)




Зураг 2.5. Дундаж үнэлгээ, компаний хэмжээгээр (2012-2018)




Зураг 2.6. Дундаж үнэлгээ, компаний үйл ажиллагааны чиглэлээр (2012-2018)

Бизнесийн орчны сөрөг үнэлгээ нэмэгдсэн боловч сүүлийн 6 сарын хугацаанд хөрөнгө оруулалтын нөхцөл байдал сайжирсан гэж үзэх аж ахуйн нэгжийн тоо эрс нэмэгдээд байна (Зураг 2.7). Энэ тоо 2016 онд 10 хувь байсан бол 2017 онд 17.3 хувьд хүрч 2018 онд 24.2 хувь болж өссөн байна. Байдал хэдийгээр сайжирсан ч, хөрөнгө оруулалтын орчин муудсан гэх аж ахуйн нэгжийн тоо, сайжирсан гэсэн аж ахуйн нэгжийн тооноос илүү хэвээр байна. Гэхдээ энэ зөрүү аажмаар багасах хандлагатай.

Зураг 2.7. Сүүлийн 6 сарын хугацаанд компаний үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Ирээдүйн хөрөнгө оруулалтын орчны 2018 оны үнэлгээ 2017 оныхтой харьцуулахад ижил хэмжээнд байгаа ба 2016 оны үзүүлэлтийг бодвол дээрдсэн байна (Зураг 2.8). Хэдийгээр бизнесийн орчны үнэлгээ муу байгаа ч судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 41.2 хувь нь ирэх 6 сард хөрөнгө оруулалтын нөхцөл байдал сайжирна хэмээн өөдрөг хүлээлттэй байгаа бол ердөө 7.3 хувь нь муудна гэсэн хүлээлттэй байна.

Зураг 2.8. Ирэх 6 сарын хугацаанд танай компаний хөрөнгө оруулалтын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх вэ?




Удирдах түвшний эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол хөрөнгө оруулалтын нөхцөл байдлын талаар илүү өөдрөг үзэл бодолтой байна. 2018 онд, эрэгтэйчүүдийн 27.4 хувь нь сүүлийн 6 сард нөхцөл байдал сайжирсан гэж мэдээлсэн бол эмэгтэйчүүдийн 22.6 хувь ийнхүү мэдээлсэн байна (Зураг 2.9). Гэсэн хэдий ч эмэгтэйчүүд ирэх 6 сарын хугацаанд хөрөнгө оруулалтын нөхцөл байдлаа илүү өөдрөгөөр төсөөлж байгаа бөгөөд тэдний 42.4 хувь нөхцөл байдал сайжирна гэсэн хүлээлттэй байна. Харин эрэгтэйчүүдийн 38.9 хувь л ийм бодолтой байна (Зураг 2.10).

Зураг 2.9. Сүүлийн 6 сарын хугацааны хөрөнгө оруулалтын нөхцөл байдлын төсөөлөл, хүйсээр




Зураг 2.10. Ирэх 6 сарын хугацаанд танай компаний үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх вэ? (хүйсээр, 2018)




2018 онд эдийн засгийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд Засгийн газрын чадавхид эргэлзэж байгаа нь судалгаанд оролцогчдын үнэлгээнээс тодорхой харагдаж байна. 2017 оныхтой харьцуулахад энэ эргэлзээ нэмэгдсэн байна (Зураг 2.11). Эдийн засгийн бодлогын хэрэгжилт “огт үр дүнгүй” байсан гэж үзсэн оролцогчдын тоо өнгөрсөн жилийн 19.4 хувиас 24.8 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 2.11. Засгийн газар эдийн засгийн бодлогоо тогтвортой хэрэгжүүлэх чадвартай эсэх



Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 67.6 хувь нь Засгийн газар эдийн засгийн бодлогоо тогтвортой хэрэгжүүлэх чадваргүй гэж үзсэн бол энэ тоо 2017 онд 62.4 хувь байсан байна.

Зураг 2.12. Эдийн засгийн бодлогоо тогтвортой хэрэгжүүлэх Засгийн газрын чадавхи



БИЗНЕСИЙН ОРЧНЫ СААД БЭРХШЭЭЛ



III. БИЗНЕСИЙН ОРЧНЫ СААД БЭРХШЭЭЛ

2018 онд бизнесийн орчинд тулгарсан хамгийн гол хоёр саад бэрхшээл нь “өндөр татвар”, “тусгай зөвшөөрөл, лицензийг шинээр авах, сунгуулах” зэрэг байна. Эдгээр асуудлын үр дагавар хэвээр байгаа нь энэ талаар мэдээлж буй судалгаанд оролцогчдын тоо нэмэгдэж байгаагаас харагдаж байна. Тухайлбал, 2016 онд “тусгай зөвшөөрөл, лиценз шинээр авах, сунгуулах” нь саад бэрхшээл болж байна гэж аж ахуйн нэгжүүдийн 17.0 хувь нь үзэж байсан бол энэ тоо 2017 онд 22.4 хувь, 2018 онд 24.8 хувь болж өссөн байна.


Эхний 2-т эрэмбэлэгдсэн саад бэрхшээл хэвэндээ байгаа хэдий ч 2018 онд мэдэгдэхүйц өөрчлөлтүүд гарсан байна. Саад бэрхшээлийн дунд “хууль эрхзүйн таагүй нөхцөл байдал” 3-р байранд орсон нь нийт судалгаанд оролцогчдын 22.1 хувь ийн үзсэнтэй холбоотой юм (Зураг 3.1-3.2). Энэхүү үзүүлэлтийг 2018 оны асуулгад шинээр нэмж оруулсан тул өмнөх жилүүдийнхтэй харьцуулах боломжгүй юм. Улс төр, эдийн засгийг бодвол хууль зүйн орчин харьцангуй тогтвортой байдаг тул өмнөх жилүүдэд бизнесийнхний хувьд байдал ижил хэмжээнд хүндрэлтэй байсан гэж үзэж болохоор байгаа юм. Бас нэг гарсан өөрчлөлт нь ажиллах хүчний мэргэжлийн үр чадвар дутмаг байгаа талаар мэдээлсэн нь өмнөх жил 14.2 хувь байсан бол 2018 онд 21.7 хувь болж нэмэгдсэн явдал юм.

“Зээлд хамрагдах боломж” гэсэн саад бэрхшээлийн хувьд мэдэгдэхүйц бууралт ажиглагдсан нь 2017 онд 21.2 хувь байсан бол 2018 онд 16.4 хувь болж буурсан явдал юм. Бусад эерэг өөрчлөлтүүдийн дунд түр болон байнгын хориг саад аль аль нь буурсан явдал ажиглагдаж байна.

Зураг 3.1. Бизнесийн орчны саад бэрхшээлүүд (олон сонголттой)




Зураг 3.2. Бизнес тулгарч буй хамгийн гол гурван саад бэрхшээл, 2012-2018 оны чиг хандлага




Асуулгын загварт өөрчлөлт, засварууд хийгдсэнтэй¹ холбогдуулан бид 2012-2017 оны хооронд төрийн байгууллагуудаас бизнес эрхлэгчдэд учруулсан саад бэрхшээлийг 2018 оны үзүүлэлттэй харьцуулах боломжгүй байна. Гэсэн хэдий ч Татварын алба нэгдүгээрт жагсаж байгаа бол Мэргэжлийн хяналтын газар болон Гааль энэхүү жагсаалтад удаалж байна (Зураг 3.3). Түүнчлэн Татварын албаны 2018 оны үзүүлэлт 2017 оныхтой харьцуулахад илт муудсан нь харагдаж байна (Зураг 3.3-3.4).


Зураг 3.3. 2012-2017 оны хооронд саад бэрхшээл учруулж буй тэргүүлэх 4 төрийн байгууллагын чиг хандлага (олон сонголт)



¹ Төрийн байгууллагуудын зарим нь татан буугдсан буюу шинээр бий болсон төрийн байгууллагуудтай нэгдсэнтэй холбогдуулан тус ангилалд өөрчлөлт орсон болно.

Зураг 3.4. 2018 оны байдлаар саад бэрхшээл учруулж буй төрийн байгууллагууд (нэг сонголттой)

Хүйсээр ялгаж харвал удирдах түвшний эмэгтэйчүүдийн “Татварын алба”-нд өгсөн үнэлгээ 27.6 хувь байсан нь эрэгтэйчүүдийн өгсөн үнэлгээ болох 18.6 хувьтай харьцуулахад маш доогуур үнэлгээ юм (Зураг 3.5). Үүний эсрэгээр Мэргэжлийн хяналтын газарт өгсөн эрэгтэйчүүдийн үнэлгээ болох 23.9 хувь нь эмэгтэйчүүдийн өгсөн 14.3 хувийн үнэлгээтэй харьцуулахад маш доогуур үнэлгээ юм. Бусад үнэлгээний хувьд зөрүүтэй байдал төдийлөн ажиглагдахгүй байна.

Зураг 3.5. Саад бэрхшээл учруулж буй төрийн байгууллагууд, хүйсээр (нэгтгэсэн)

АЛДАГДАЛ БУЮУ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛАЛТ




IV. АЛДАГДАЛ БУЮУ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛАЛТ


2018 оны байдлаар судалгаанд оролцогчдын ердөө 10.3 хувь нь л өөрийн цаг хугацааны 50-аас дээш хувийг үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд зарцуулдаг гэж мэдэгдсэн байна (Зураг 4.1). Энэ нь 2012 оноос хойш бүртгэгдсэн хамгийн доод үзүүлэлт юм. Өмнөх жилтэй харьцуулахад цаг хугацаагаа алддаггүй хүмүүсийн тоо хамаагүй өссөн үзүүлэлттэй байна.

Байгууллагын хөрөнгө мөнгө зарцуулалтын тал дээр өөр дүр зураг ажиглагдаж байна (Зураг 4.2). 2017 онд судалгаанд оролцогчдын ердөө 7 хувь нь л өөрийн хөрөнгө, мөнгөний 25-аас дээш хувийг үйлдвэрлэлийн бус асуудал бэрхшээлийг шийдвэрлэхэд зарцуулдаг гэж мэдээлсэн бол 2018 онд энэ тоо 9.4 хувь болж өссөн байна. Гэсэн хэдий ч энэ тоо олон жилийн турш тогтвортой байгаа тул энэхүү бага зэргийн өөрчлөлт нь ач холбогдол багатай юм.

Зураг 4.1. Үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд компаний удирдлагын зарцуулж буй цаг хугацаа




Зураг 4.2. Үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдвэрлэхэд байгууллагаас зарцуулж буй нөөц




Санал асуулгын дүнг хүйсээр ангилж үзвэл дүнд удирдах түвшний эмэгтэйчүүд ялимгүй их цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулдаг гэж мэдээлжээ (Зураг 4.3-4.4). Эмэгтэйчүүдийн 12.0 хувь нь өөрийн цаг хугацааны 50-аас дээш хувийг зарцуулдаг гэсэн бол эрэгтэйчүүдийн ердөө 7.1 хувь ийн мэдээлсэн байна. Үүний адилаар эмэгтэйчүүдийн 10.6 хувь байгууллагын хөрөнгийн 25-аас дээш хувийг зарцуулдаг гэсэн бол эрэгтэйчүүдийн ердөө 7.1 хувь л ингэж хариулсан байна.

Зураг 4.3. Үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдвэрлэхэд компаний зарцуулж буй хугацаа (2018 он, хүйсээр)



Зураг 4.4. Үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдвэрлэхэд компаний зарцуулж буй нөөц (2018 он, хүйсээр)



ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АВЛИГА




V. ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АВЛИГА


Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг “Монголын эдийн засгийн тойм”-ын 2018 оны 7-р сарын дугаарт төрийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, “ихэнх төсөл хөтөлбөрүүд хэрэгжих боломжгүй, бодит бус бөгөөд сүүлийн жилүүдэд гарсан санхүүгийн хямралд нөлөөлсөн” гэж дүгнэжээ. Тэдгээр үр дүнгүй төсөл хөтөлбөрүүд ирээдүйд ч үргэлжлэх үр нөлөөгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Монгол Улсын дэлхийд өрсөлдөх чадварын индекс 2016-2017 онд мэдэгдэхүйц сайжирч 124-р байрнаас 101-р байрт эрэмбэлэгдсэн хэдий ч төсвийн үр ашиггүй зарцуулалтаараа хамгийн дээгүүрт жагсдаг орнуудын нэг юм. “Монголын эдийн засгийн тойм”-д төрөөс чанаргүй төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд хүргэж буй үндсэн 3 хүчин зүйлийг дурьджээ. Нэгдүгээрт, бодлогын алдаа буюу төсөл хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулахдаа тэдгээрийн тогтвортой, үр ашигтай байдлыг зохих ёсоор харгалзан үздэггүй явдал. Хоёрдугаарт, шийдвэр гаргах эрх мэдлийг хэтэрхий нарийвчлан задалсан явдал бөгөөд үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг яам, агентлагийн үйл ажиллагаатай холбоотой. Гуравдугаарт төслийн үнэлгээний тохиромжтой аргачлалыг боловсруулах, хэрэгжүүлэхэд анхаарал бага хандуулдагтай холбоотой.

Судалгааны тайлангийн I болон III бүлэгт бид төрийн салбарын үр ашиг багатай байдал бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлдөг болохыг, түүнчлэн бизнэс эрхлэгчдэд зардал, чирэгдэл учруулдаг талаар танилцуулсан билээ. Энэхүү тайлангийн V бүлэгт төрийн салбарын энэхүү үр ашиггүй байдлыг өөр нэг хүчин зүйл болох авлигатай холбоотойгоор судалсан болно. Хэдийгээр 2017 оноос эхлэн төрийн албан дахь авлига хамгийн их гэж тогтмол үнэлж байгаа ч (Зураг 5.1-5.2) ерөнхийд нь авч үзвэл бага зэрэг эерэг чиг хандлага ажиглагдаж байгаа юм. Хэрэв 2015 оны 9-р сарын байдлаар дундаж үзүүлэлт хамгийн доод түвшинд буюу 1.57 байсан бол, 2016 онд 1.58, 2017 онд 1.62 болон өсөж, 2018 онд 1.65-д хүрсэн байна (Зураг 5.2). Гэвч судалгаанд оролцогчдын бараг тэн хагас нь төрийн албан дахь авлигын түвшин өндөр гэж үзсэн хэвээр байна.

Зураг 5.1. Таны бодлоор төрийн албанд авлига хэр их байгаа вэ?




Зураг 5.2. Төрийн албан дахь авлига (Үнэлгээ – 1: “маш их”, 2: “тодорхой хэмжээнд байгаа”, 3: “бага зэрэг”, 4: “байхгүй”)



2018 онд авлигын тохиолдлын давтамж 2012 оноос хойш хамгийн бага хэмжээнд хүрээд байгаа юм (Зураг 5.3-5.5). 2018 онд авлигатай “хэзээ ч” нүүр тулгарч байгаагүй гэж мэдээлсэн судалгаанд оролцогчдын тоо 9.4 хувиас 18.5 хувь болж өссөн байна (Зураг 5.3). Үүнтэй холбогдуулан авлигын тохиолдлын талаар мэдээлсэн компаний тоо мөн буурсан байна.


Зураг 5.3. Танай бизнесийн салбарт компаний зүгээс төрийн байгууллагад авлига өгсөн тохиолдлыг мэдэх үү? (зөвхөн бодит хариултууд²).




² “Мэдэхгүй байна” эсвэл “хариулаагүй” зэрэг хариултуудыг ангиллын хүснэгтэд оруулаагүй болно. Дундажийн хувьд энэ нь ойролцоогоор 30 хувьтай байна.

Үүнээс гадна авлигын тохиолдолтой “байнга” тулгардаг гэж хариулсан хүний тоо 2017 онд 35.3 хувь байсан бол 2018 онд 29.7 хувь болж буурсан байна (Зураг 5.4). 2012 оноос эхлэн төрийн тендертэй холбоотой авлигын асуудал аажмаар буурч байгаагийн бас нэг илрэл юм (Зураг 5.5).

Зураг 5.4. Төрийн тендерт оролцох, гэрээ байгуулахад авлигатай тулгарч буй давтамж.



Зураг 5.5. Төрийн албан дахь авлигын дундаж давтамж (1-ээс буюу “байнга” 4 хүртэл буюу “хэзээ ч гардаггүй”)



2016-2018 оны хооронд авлигад хамгийн ихээр өртсөн төрийн байгууллагуудын чиг хандлагыг ажиглахад бизнес эрхлэгчид дараахь 3 байгууллага буюу татварын алба, мэргэжлийн хяналт, гаалийг нэрлэсэн байна (Зураг 5.6). Татварын алба 2016 онд 29.1 хувиар жагсаалтыг тэргүүлж байсан бол 2017 онд 18.8 хувь болж эрс бууран гуравдугаарт эрэмбэлэгджээ. 2018 оны байдлаар Татварын албаны үнэлгээ 24.8 хувьд хүрч хоёрдугаарт орсон байна. 2018 онд бизнесийн орчны үнэлгээ


буурсан байдал, өндөр татварыг бэрхшээл гэж үзэх давтамж өссөн явдал, түүнчлэн татварын албыг авлигад хамгийн ихээр өртсөн төрийн байгууллага гэж үзсэн үнэлгээ хоорондын харилцан хамаарал мэдэгдэхүйц байна.

Мэргэжлийн хяналтын газар 2016 онд 2-р байр (27.6 хувь)-аас 2017 онд 1-т (25.2 хувь) орсон бол 2018 онд 1-т (28.8 хувь) эрэмбэлэгдсэн хэвээр байна. Гаалийн байгууллагын эрэмбэ өөрчлөгдсөн хэдий ч дээгүүр жагссан хэвээр байна. Тус байгууллага нь 2016 онд 3-т (25.5 хувь) орж байсан бол 2017 онд 2-т (23 хувь), 2018 онд 3-т (18.8 хувь) эрэмбэлэгдсэн үзүүлэлттэй байна. Хэдийгээр өндөр үзүүлэлттэй байгаа ч 2016-2018 онд Гаалийн байгууллагыг дурьдсан хүний тоо тогтмол буурч байгаа юм.³

2016, 2017 онд Газрын алба 18.2 болон 17.3 хувиар тус тус 4-рт жагсаж байсан бол 2018 онд “Шүүх” хэмээх шинэ ангиллыг нэмж оруулснаар Газрын алба 5-рт (11.8 хувь) жагсаж, “Шүүх” 4-рт (16.1 хувь) орсон байна. Газрын албыг дурьдсан хүний тоо мөн сүүлийн 2 жилд буурсан байна.


Зураг 5.6. Бизнес эрхлэж байхдаа таны ажигласнаар дараах төрийн байгууллагын аль нь авлигад хамгийн их өртдөг вэ? (олон сонголттой)

а)




³ Эдгээр өөрчлөлтүүдийг шууд харьцуулах нь асуудалтай байгаа нь 2018 оны судалгаанд нэвтрүүлсэн зарим аргазүйн өөрчлөлттэй холбоотой юм.

б)




в)



2018 онд төрийн албан дахь авлига нь тэдгээрийн үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг гэж үзсэн судалгаанд оролцогчдын тоо 2017 оныхтой ижил түвшинд байгаа ч түүнээс өмнөх жилүүдтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна (Зураг 5.7). Энэхүү чиг хандлагаас үл хамааран энэ үзүүлэлт өндөр хэвээр байгаа бөгөөд нийт судалгаанд оролцогчдын гуравны нэгээс илүү хувь буюу 37.6 хувь нь шууд нөлөөлдөг гэж мэдээлсэн юм. Энэ нь хувийн хэвшилд үзүүлж буй төрийн үйлчигээг үр нөлөөгүй хэмээн үнэлэхэд хүргэж буй сөрөг нөлөө бүхий үзүүлэлт юм.

Зураг 5.7. Төрийн албан дахь авлигын шууд нөлөөлөл




Шууд нөлөөлдөг гэж мэдэгдсэн компаниудын бараг гуравны нэг нь буюу 28.2 хувь нь тэдгээрийн бизнест “маш ихээр” нөлөөлдөг гэж мэдээлсэн бол тэн хагасаас бага зэрэг илүү хувь нь буюу 50.8 хувь нь “тодорхой хэмжээгээр” нөлөөлөл үзүүлдэг гэж мэдэгдсэн байна.

Зураг 5.8. Бизнесийн үйл ажиллагаанд төрийн албан дахь авлигын үзүүлж буй нөлөө.




Ойрын жилүүдэд Засгийн газрын тендерт оролцогчдын тоо бага зэрэг нэмэгдэж 26.7 хувьд хүрчээ (Зураг 5.9). Гэсэн хэдий ч судалгаанд оролцогчдоос тендерт оролцох сонирхолтой хүмүүсийн тоо өмнөх жилүүдийн санал асуулгын дүнгээс бага хэвээр байна. Бүхэлд нь авч үзвэл, Монгол ардын намын засаглалын үед тендерт оролцогчдын тоо Ардчилсан намын засаглалын үеийн тендерт оролцогчдын тооноос бага байна. Гэсэн хэдий ч төрийн албан дахь авлигын бизнест үзүүлж буй нөлөөний үнэлгээ бага байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын ердөө аравны нэг нь л маш ихээр нөлөөлж байна гэж үзсэн байна (Зураг 5.10).

Зураг 5.9. Засгийн газрын тендерт оролцсон байдал



Зураг 5.10. Их авлига буюу дээд түвшний авлигын бизнест үзүүлж буй нөлөө




Төрийн албан дахь авлигын холбоо сүлбээг авч үзвэл судалгаанд оролцогчдын 42.1 хувь нь хувь хүн, болон зохион байгуулалттай бүлэглэлийн аль алиар нь дамждаг гэж үзсэн байна (Зураг 5.11). Гэхдээ судалгаанд оролцогчдын 31.8 хувь нь төрийн албан дахь авлигад илүү зохион байгуулалттай бүлэглэл оролцож байна гэж үзсэн байна. Хувь хүмүүс дийлэнх байна гэж үзсэн судалгаанд оролцогчдын тоо багассан үзүүлэлттэй байна. Сүүлийн 4 жилийн хугацаанд энэ тоо 2015 онд 21.8 хувиас 2018 онд 14.5 хувь болж буурсан үзүүлэлттэй байна. Энэхүү чиг хандлагаар Засгийн газрын тендер дэх авлига нь “уламжлалт” буюу хувийн харилцааны журмаар явагддаг авлигыг бодвол илүү ээдрээтэй гэх үзлийг улам бататгаж байгаа юм.

Зураг 5.11. Төрийн алба дахь авлигыг тархааж буй суваг.



ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ АВЛИГА



VI. ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ АВЛИГА


Хувийн хэвшил дэх авлигын үнэлгээ төрийн албан дахь авлигын үнэлгээтэй харьцуулахад илүү дээр үзүүлэлттэй байна (Зураг 6.1-6.2). 2018 онд судалгаанд оролцогчдын 27.6 хувь нь хувийн хэвшилд авлига байхгүй (Зураг 6.1) гэж үзсэн бол судалгаанд оролцогчдын ердөө 1.2 хувь л төрийн албанд авлига байхгүй гэж мэдээлсэн байна (Зураг 5.1). Үндэсний Статистикийн Хорооны тайланд хэвлэгдэн гарсан АТГ-аас мэдүүлсэн тоо баримт нь энэхүү үнэлгээн дэх зөрүүг баталж байгаа юм. Хүснэгт 6.1-т АТГ-аас ирүүлсэн авлигаас үүдэлтэй хохирлын талаар харуулсан ба төрд учруулсан хохирол нь хувийн хэвшилд учруулсан хохирлоос дунджаар 20 дахин илүү байгааг үзүүлж байна. Эдгээр тоон үзүүлэлтээс 2016 болон 2018 оны үр дүн ижил түвшинд байгааг харж болох бөгөөд энэхүү судалгааны хамгийн эхний жилээс өдрийг хүртэл хувийн хэвшлийн зүгээс тасралтгүй үнэлж ирсэн үзүүлэлт билээ (Зураг 6.1б).

Хүснэгт 6.1. Авлигын гэмт хэргээс учирсан хохирол (тэрбум ₮).⁴

	2010	2015	2016	2017
Төрийн өмч	24.1	35.8	31.9	63.2
Хувийн өмч	1.0	2.9	1.3	3.3


Зураг 6.1. Хувийн хэвшил дэх авлигын үнэлгээ

а)




⁴ Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 2017

б) Хувийн хэвшил дэх авлигын үнэлгээ (1-с буюу “маш их” 4 хүртэл буюу “байхгүй”).




Санал асуулгын дүнг хүйсээр ангилж харвал 2018 онд удирдах түвшний эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад хувийн хэвшил дэх авлига бага хэмээн үзжээ.

Зураг 6.2. Хувийн хэвшил дэх авлига (хүйсээр)



Хувийн хэвшлийн салбарт гэрээ байгуулах болон тендерт оролцох үйл ажиллагаан дахь авлигын талаарх 2018 оны судалгаанд оролцогчдын үнэлгээ хамгийн доод түвшинд хүрсэн (Зураг 6.3). 2012 онд судалгаанд оролцогчдын 24.8 хувь нь хувийн хэвшлийн гэрээ байгуулах болон тендерийн үйл ажиллагаанд авлига “байнга” ажиглагддаг гэж үзэж байсан бол 2018 онд энэ тоо 9.7 хувь болж буурсан байна. 2012 онд судалгаанд оролцогчдын 3.3 хувь авлига “огт байхгүй” гэж үзэж байсан бол 2018 онд энэ тоо 12.7 хувь болж өссөн байна.


в)




Бизнесийн үйл ажиллагаанд авилгын тохиолдол 2017 оныхтой харьцуулбал 2018 онд харьцангуй дээрдсэн боловч 2016 онтой харьцуулахад тааруу байна (Зураг 6.4). 2018 онд судалгаанд оролцогчдын тавны нэгээс илүү хувь (22.7 хувь) нь авлигын асуудал “хэзээ ч” тулгарч байгаагүй гэж мэдээлсэн бол маш бага хувь (6.1 хувь) нь энэ асуудал “байнга” тулгардаг гэж мэдээлсэн байна. Иймд бага зэргийн хэлбэлзлийг эс тооцвол хувийн хэвшил дэх авлигын нөхцөл байдал төрийн тендер болон гэрээ байгуулах үйл ажиллагаанд тохиолддог авлигатай харьцуулахад ерөнхийдөө тогтвортой сайжирч байна.

Зураг 6.4. Танай бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулахад авлига хэр их тохиолддог вэ?


а)



б) Авлигын тохиолдолын дундаж (1-с буюу “байнга” 4 хүртэл буюу “хэзээ ч тохиолддоггүй”)




в)




Бизнесийн үйл ажиллагаанд авлигатай тулгарах асуудал салбараасаа шалтгаалж нэлээд ялгаатай байдаг талаар Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааны өмнөх тайлангуудад дурьдаж байсан билээ (Зураг 6.5). 2018 онд үйлчилгээний салбарын нөхцөл байдлын ерөнхий үнэлгээ өмнөх жилийнхтэй харьцуулахад сайжирсан бол худалдааны салбарын хувьд муудсан үзүүлэлттэй байна. 2018 оны хувьд нэг ялгаатай зүйл нь өмнөх жилүүдтэй харьцуулахад авлига байгаа эсэхийг тодорхойлж чадахгүй байгаа хүмүүсийн тоо өндөр байгаа явдал юм. Тухайлбал, үйлдвэрлэлийн салбарын судалгаанд оролцогчдын тавны нэг (20.7 хувь) нь, мөн барилгын салбарын 31.4 хувь юм. Үүнээс гадна дээрх 2 салбарын үнэлгээ өмнөх жилээс улам муудсан үзүүлэлттэй байна.

Зураг 6.5. Танай салбарын бизнесийн үйл ажиллагаанд авлига хэр их тохиолддог вэ?


а)




б)



в)




г)




Сүүлийн жилүүдэд төрийн албаны авлигад өртөмтгий байдалд өгсөн эерэг үнэлгээ 2018 онд эрс өөрчлөгджээ (Зураг 6.6). Судалгаанд оролцогчдын дийлэнх (71,5 хувь) нь төрийн алба авлигад өртөмтгий гэж мэдээлсэн нь 2012 оноос хойш ажиглагдсан хамгийн өндөр үзүүлэлт юм. Уул уурхайн салбарын нөхцөл байдал (58,2 хувь) мөн өмнөх жилтэй харьцуулахад муудсан үзүүлэлттэй байна. Үүнтэй харьцуулахад барилгын салбарын үнэлгээ тогтвортой байгаа бол, санхүү болон үйлдвэрлэлийн салбарын нөхцөл байдал сайжирч байна. Эрчим хүч, дулаан болон усан хангамжийн салбар сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байгаа бөгөөд авлигад хамгийн бага өртөмтгий салбаруудын тоонд багтаж байна.

Зураг 6.6. Авлигад хамгийн өртөмтгий салбарууд (олон сонголттой).


а)




б)




в)




г)




д)




е)



ё)




ж)



Засгийн газарт зохих ёсоор татвараа төлдөг компаний тоо 2015 оноос хойш тогтмол нэмэгдэж байна (Зураг 6.7). 2017 онтой харьцуулахад 2018 оны байдлаар “барэг бүх компани” гэж мэдээлсэн хүний тоо 2.5 хувиар нэмэгдэж 15.8 хувьд хүрсэн бол “ихэнх компани” гэсэн хариулт 7.3 хувиар нэмэгдэж 46.4 хувьд хүрсэн байна.

Зураг 6.7. Танай салбарт хэр олон компани татвараа зохих ёсоор нь /хуулийн дагуу/ төлдөг вэ? (зөвхөн бодит хариултауд)



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА




VII. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


Засгийн газраас авлигатай тэмцэх чиглэлээр гаргаж буй хүчин чармайлтын талаар судалгаанд оролцогчдын мэдлэг бага буюу талаас илүү хувь нь мэдлэг, мэдээлэл огт эсвэл бараг байхгүй гэж мэдэгдсэн байна. 2018 оны байдлаар Засгийн газраас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааны талаар судалгаанд оролцогчдын мэдлэгийн түвшин 2017 оныхтой ижил хэмжээнд байна (Зураг 7.1). Судалгаанд оролцогчдын нийт 62.8 хувь нь “огт мэдээлэл байхгүй” эсвэл “бараг мэдээлэл байхгүй” гэсэн бол 2018 онд энэ тоо бага зэрэг нэмэгдэж 66 хувьд хүрсэн байна. 7 жилийн чиг хандлагыг харвал сайжирсан ямар ч шинж тэмдэг байхгүй, харин мүүдсэн дүр зураг ажиглагдаж байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын маш цөөн хэсэг нь “мэдлэг, мэдээлэлтэй” гэж хариулсан байна.

Зураг 7.1. Та одоогийн Засгийн газраас явуулж байгаа авлигын эсрэг үйл ажиллагааны талаар хэр сайн мэдэх вэ?

а)



б) Мэдээллийн хэмжээ: 1-с буюу “маш их” 4 хүртэл буюу “огт мэдэхгүй”.




Дээрхтэй адилаар эрх баригчдын зүгээс авлигатай тэмцэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны үр нөлөөнд бизнес эрхлэгчид үл итгэх хандлагатай байна (Зураг 7.2). 2017 онд судалгаанд оролцогчдын дийлэнх (72.1 хувь) нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжууд нь бизнесийн орчныг ил тод, авлигаас ангид болгоход “ямар ч үр дүнгүй” буюу “үр дүн багатай” гэж хариулсан байна. 2018 онд энэ тоо өндөр хэвээр буюу 70.6 хувьтай байна. Нөхцөл байдлын ерөнхий чиг хандлага сөрөг байх төлөвтэй байна.

Зураг 7.2. Бизнесийн орчныг ил тод, авлигаас ангид болгоход хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын үр нөлөөтэй байдал




б) Үнэлгээ 1 - “маш үр дүнтэй” 4 - “огт үр дүнгүй”




2018 онд судалгаанд оролцогчдод өөрийн бизнесийн чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй авлигатай тэмцэх арга хэмжээний үр нөлөөг үнэлэхэд хүндрэлтэй байсан юм (Зураг 7.3). Судалгаанд оролцогчдын гуравны нэгээс илүү хувь (39.4 хувь) нь Засгийн газрын хүчин чармайлтыг үнэлж чадаагүй бол, нөгөө тал (51.8 хувь) нь хэвэндээ байгаа гэж мэдээлсэн байна.

Зураг 7.3. Засгийн газраас авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөө

Авлигатай тэмцэх хууль эрхзүйн орчин, Засгийн газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа үр дүнтэй эсэхэд хийсэн үнэлгээ аль аль нь мүү үзүүлэлттэй байна (Зураг 7.4). 2018 оны байдлаар судалгаанд оролцогчдын бараг тэн хагас (47.6 хувь) нь “огт үр дүнгүй” гэж үзжээ. 2012 онд санал асуулгыг анх эхлүүлж байснаас хойш Энэ нь хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа ба тус онд ердөө тавны нэг (19.4 хувь) нь ямар ч үр дүнгүй гэж үзэж байжээ. Тоймлон харвал сөрөг үнэлгээ улам нэмэгдэх хандлагатай байна.

Зураг 7.4. Таны бодлоор Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээнүүд Монгол улсыг авлигагүй болгоход хэр үр нөлөөтэй байна вэ?

б) Үнэлгээ 1 - “маш үр дүнтэй” 4 - “огт үр дүнгүй”



АТГ-ын статистик мэдээллээс харахад прокурорт шилжүүлсэн хэргийн тоо нэмэгдсээр байна (Хүснэгт 7.1). 2017 онд урьд өмнө нь байгаагүй их хэмжээгээр авлигын хэрэг (106)-ийг шилжүүлсэн бөгөөд хэрэгт холбогдсон хувь хүний тоо (189) багассан үзүүлэлттэй байна. Өмнөх жилүүдэд зохион байгуулалттай бүлэглэлүүдийн оролцоо илүү их байсантай харьцуулахад авлигын ганцаарчилсан тохиолдлын тоо нэмэгдсэн байна (Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 2017, ҮСХ). Өмнөх жилүүдэд тохиолдол тус бүрт холбогдох хувь хүний тоо харьцангуй их байсан юм.

Гэсэн хэдий ч АТГ-аас шилжүүлсэн хэргийн тоон үзүүлэлт нь хэрэг тус бүрт яллах үйл ажиллагаа явуулсан хэргийн тоог илэрхийлээгүй болно. Тиймээс судалгаанд оролцогчдын анхаарал татсан зарим хэргүүдийг АТГ шийдвэрлэсэн гэж ойлгож болохгүй. Үүний улмаас авлигад холбогдсон төрийн албан тушаалтнуудад төр шийтгэл ногдуулах чадваргүй байна гэсэн дургүйцэл олон нийтийн дунд ихэсч байна (Зураг 7.5). Энэхүү бухимдал нь 2017-2018 оны хооронд дээд цэгтээ хүрсэн байна. 2017 онд судалгаанд оролцогчдын дийлэнх олонх (судалгаанд оролцогчдын 89.7 хувь) нь авлигад өртсөн төрийн албан тушаалтнуудад “ховорхон тохиолдолд” эсвэл “хэзээ ч” хариуцлага ноогдуулдаггүй гэсэн дүгнэлтэд хүрсэн ба 2018 онд мөн ижил хэмжээний дийлэнх олонх (90.3 хувь) ижил хариултыг өгсөн байна.

Энэ нь эргэлзээгүй АТГ-ын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ буурч буйтай холбоотой юм (Зураг 7.6). 2016-2018 оны хооронд бизнес эрхлэгчдийн дунд явуулсан бидний судалгаанд сөрөг үнэлгээ давамгайлж байгаа бөгөөд энэхүү хандлага нь хүн амын ерөнхий санал асуулга (Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа) 5-аас нилээд урт хугацааны туршид ажиглагдаж байгаа үзэгдэл юм. АТГ-т өгсөн сөрөг үнэлгээ нь олон жилийн турш маш тодорхой байгаа бөгөөд судалгаанд оролцогчид тус байгууллагын үйл ажиллагаа зөв зүгт чиглэж байгаа эсэхэд эргэлзэж байгаа гэсэн дүгнэлттэй мөн тохирч байгаа юм (Зураг 7.7). Судалгаанд оролцогчдын ердөө 10.6 хувь нь л АТГ зөв чиглэлд явж байна гэж дүгнэсэн бол үүний эсрэг 41.5 хувь нь буруу чигт явж байна гэж үзсэн байна Судалгаанд оролцогчдын бараг тэн хагас (47.9 хувь) нь энэ талаар ямар нэгэн үзэл бодолгүй байна.


Хүснэгт 7.1. Авлигатай тэмцэх газраас шалгаад, прокурорт шилжүүлсэн хэргийн тоо.⁶

	2010	2015	2016	2017
Тохиолдол	39	55	67	106
Хувь хүн	144	167	206	189
1 хүнд ногдох тохиолдлын дундаж	3.7	3.0	3.1	1.8

⁵ Судалгааны линк: <https://asiafoundation.org/where-we-work/mongolia/> эсвэл <http://www.santmaral.org/>

⁶ Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 2017, ҮСХ


Зураг 7.5. Таны бодлоор авлигад холбогдсон төрийн албан тушаалтнуудад Засгийн газар хариуцлага тооцож чадаж байна уу?



Зураг 7.6. АТГ-аас явуулж буй үйл ажиллагааны үнэлгээ





Зураг 7.7. АТГ-ын үйл ажиллагаа зөв зүгт чиглэж байна үү?



Төрийн албан дахь авлига болон бизнесийн үйл ажиллагаа хоорондын харилцан хамаарлын үнэлгээнд судалгаанд оролцогчдын бараг тэн хагас нь төрийн албаны авлига багассан тохиолдолд илүү өндөр ашиг орлоготой ажиллана гэсэн хүлээлттэй байна (Зураг 7.8). 2017 ба 2018 онуудын үзүүлэлтээс ажиглагдсан нэг сонирхолтой зүйл нь төрийн албан дахь авлигаас хамааралтай байдаг гэж мэдээлсэн судалгаанд оролцогчдын тоо өссөөр байна (Зураг 7.9). Авлига буурвал ашиг орлого нь буурна гэж тооцолж байгаа судалгаанд оролцогчдын тоо 2012 онд 1.2 хувь байсан бол 2018 онд 4.2 хувь болж өссөн байна.


Зураг 7.8. Төрийн албан дахь авлига буурснаар үзүүлэх үр нөлөө




Зураг 7.9. Төрийн албаны авлига багассанаар танай компаний ашиг орлого буурах эсэх

2015 оноос хойш авлигатай тэмцэх чиглэлээр тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлж буй компаниудын тоонд бага зэргийн эерэг өөрчлөлт ажиглагдаж байна. Энэ тоо 2015 онд 10.9 хувь байсан бол 2018 онд 17.3 хувь болж өссөн үзүүлэлттэй байна (Зураг 7.10). Энэхүү үйл ажиллагаа нь авлигын талаар мэдээлэхээс өөр зүйл ба авлигын талаар мэдээлэх хүсэлтэй судалгаанд оролцогчдын тоо дээрхи хугацаанд 8.5 хувиас 5.2 хувь болж буурсан үзүүлэлттэй байна (Зураг 7.11). Мэдээлэхгүй байгаа үндсэн шалтгаан нь үр дүн багатай гэж үзсэнтэй холбон тайлбарлаж болохоор харагдаж байгаа юм (Зураг 7.12). Авлигын талаар мэдээлсэн оролцогчдын тавны нэг нь л энэ үйлдэл нь үр дүнтэй байдаг гэж мэдэгдсэн байна.


Сайжирсан гэж үзэж болох зүйлсийн нэг нь авлигатай тэмцэх чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулсан компаниудын тоо нэмэгдсэн явдал юм. Авлигатай тэмцэх чиглэлээр бодлого боловсруулсан гэж мэдэгдсэн компаний тоо 2018 онд хамгийн их буюу 20 хувь байсан бол өмнөх жил нь 13.9 хувь байсан байна (Зураг 7.13). Гэсэн хэдий ч компаниудын дийлэнх олонх нь ийм бодлогын баримт бичиггүй байсан хэвээр байна.

Зураг 7.10. Авлигатай тэмцэх чиглэлээр авсан арга хэмжээ


Зураг 7.11. Авлигын тохиолдлын талаар мэдээлсэн байдал



Зураг 7.12. Хэрэв мэдээлсэн бол, үр дүнд хүрсэн эсэх



Зураг 7.13. Авлигатай тэмцэх дотоод журамтай эсэх



Авлигатай тэмцэх үндсэн аргуудын нэг нь бизнесийн үйл ажиллагаандаа шударга зарчмыг үргэлж баримтлах явдал юм (Зураг 7.14). 2017 он (45.8 хувь) болон 2018 (43,6 хувь) онд энэхүү зарчмыг судалгаанд оролцогчдын бараг тэн хагас нь дэмжсэн юм. Өнгөрсөн жилийн хугацаанд “хэзээ ч авлига өгөхгүй” гэж мэдэгдсэн судалгаанд оролцогчдын хувь эрс нэмэгдэж 15.2 хувиас 25.2 хувь болж өссөн байна. Сонгууль ойртохын хэрээр авлигад холбогдсон улс төрчдийн эсрэг кампанит ажил зохион байгуулах хүсэлтэй хүмүүсийн тоо мөн нэмэгдэж байна. Тэдгээр хүмүүсийн тоо бага хэмжээгээр нэмэгдсэн буюу 6.1 хувиас 9.1 хувь болж өссөн байна.

Зураг 7.14. Бизнесийн орчин дахь авлигын эсрэг үйл ажиллагаа

